



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/02

Цагаан-Уул сум

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд сумын Засаг даргын Тамгын газрын тээвэр шатахуун нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ахлагч: М.Оюунчимэг (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Гишүүд: Б.Ичинхорлоо (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: А.Хишигбаяр (Төрийн сангийн мэргэжилтэн)

2. Техникийн тодорхойлолтыг боловсруулж үнэ дуудах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж зөвлөмж ирүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (М.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/